

**МОНГОЛ УС ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/20/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 26166 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 26188 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Г.Мөнхчимэг
Утас: 261740 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn

“Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн захирал Г.Энхмаа
Утас:99040059 450279 Цахим хаяг: Enkhmaa_56@yahoo.com

Чанарын хяналтын мэргэжилтэн Л.Оюунцэцэг
Утас: 99073014 Цахим хаяг: oyuntsetsegl@yahoo.com

Аудитор Н.Уранчимэг
Утас: 91093898 Цахим хаяг: urnaa_mhg@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	4
2.9.1	Авлагын талаар.....	4
2.9.2	Бараа материалын талаар.....	4
2.9.3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар.....	4
2.9.4	Дотоод хяналтын талаар.....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	5-7
3.1	Авлагын талаар	8
3.2	Бараа материалын талаар	9
3.3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	10
3.4	Дотоод хяналтын талаар	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн гүйцэтгэл.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийгдсэн зорилтот түвшингийн тайлан.....	17



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УС ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.БИЛЭГСАЙХАН
ТАНАА

2018.03.15 № 06/746
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монгол Ус" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Монгол Ус" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Монгол Ус" ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.201\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG77.Docx

071212

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

"Монгол Ус" ТӨААТҮГ-нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1 Аудитын тайлан

1.1 Оршил

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Монгол Ус” ТӨААТҮГ-ын дарга Г.Билэгсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд байгууллагын танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар”-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Монгол Ус” ТӨААТҮГ-нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 02 дугаар сарын 28-наас 2018 оны 03 дугаар сарын 13-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, “Монгол Ус” ТӨААТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Н.Уранчимэг, чанарын хяналтын менежер Л.Оюунцэцэг, аудиторын туслах Д.Должидмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

САГ-2018-/20/СТА-ТӨҮГ

Аудитаар “Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Монгол Ус” ТӨААТҮГ-ын захирлын 2018 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн 1/34 тоот албан бичгээр “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь :

Монгол Улсын нутаг дэвсгэрт усны менежмент хийх, Ус үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх, усны нөөцийн менежмент хийх, төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж, түүний ашиглалт засвар үйлчилгээг хариуцан ажиллах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

-Хоногт 100 шоо метрээс их ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гаргах

-Улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул, судалгаа явуулж, нөөц нь тогтоогдсон ордуудын нөхөн төлбөрийг тооцож, улсын төсөвт төвлөрүүлэх

-Усан тээврийн зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт гаргах

-Хоногт 50 шоо метрээс их аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчдад хаягдал ус зайлуулах тухай дүгнэлт гаргах

- Байгууллагын дэргэдэх усны төв лаборатори нь цэвэр бохир усны химийн болон бактериологийн шинжилгээ хийх зэрэг нь тус байгууллагын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл байна.

“Монгол Ус” ТӨААТҮГ санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/ зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна. “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 280 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Ус” ТӨУҮГ-ын бүтцийг 37 орон тоотойгоор баталсан байна.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрдэлийг үүсгэж баримтжууллаа.

01

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 6 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 16 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.8 дахь заалтад хураангуйлан тэмдэглэв.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Монгол Ус” ТӨААТҮГ-нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Ди Би Ай Эс” ХХК-ийн Диамонд санхүүгийн програм хангамжаар бэлтгэсэн байна.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 368 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орлогыг 585.0 сая төгрөгөөр, зардлыг 583.0 сая төгрөгөөр шинэчлэн баталсан байна.


Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 597.5 сая төгрөг, хүүгийн орлого 1.3 сая төгрөг нийт 598.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, борлуулалтын өртөгт 193.8 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 377.8 сая төгрөг, бусад зардалд 0.57 сая төгрөг зарцуулж 26.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

1.6 Шилэн дансны мэдээлэл

“Монгол Ус” ТӨААТҮГ-нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг бүрэн оруулаагүй байна. Шилэн дансны сайтад байгууллагын хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөв, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, жагсаалт, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээлэл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, санхүүгийн тайланг сүүлийн 8 сараар оруулж Шилэн дансанд эхний 4 сарын мэдээллийг шивээгүй байна.

1.7 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлээр эрсдэл төлөсж, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 16 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.



Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.8-д хураангуйлан тэмдэглэв.

1.8 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.8.1 Авлагын талаар

Тус байгууллага нь “Хөөсгөл” ХХК-иас ажлын хөлс 6.0 сая төгрөг, өмнө нь ажиллаж байсан удирдлагатай холбоотой 6.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өглөө.

1.8.2 Бараа материалын тайлангийн талаар

Тайлант жилд бараа материалын тайланг эхний 5 сарын байдлаар хангалтгүй бэлтгэсэн, шатах, тослох материалын тайланг бэлтгээгүй, 4.8 сая төгрөгийн хангамжийн материал, 6.9 сая төгрөгийн шатах тослох материалыг шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон бараа материалын бүртгэлийн байнгын системийн аргаар бүртгэхийг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж болон албан шаардлага өгөв.

1.8.3 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар


Тус байгууллага нь үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо хүчингүй болсон Засгийн газрын 233 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан нь /НББОУС/-16-г мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өглөө.

1.8.4 Дотоод хяналтын талаар

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй нь “Нийтлэг журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын 2.2-т “Дотоод хяналт шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өглөө.



1.9 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

2018 оны завсрын аудитаар “Монгол Ус” ТӨААТҮГ-ын орлогын бүрдүүлэлтийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

1.11 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар агуулга шинж чанарын хувьд материаллаг бус, нийт 24.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгөв.

1.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөнөөс 3 зөвлөмжийг биелүүлсэн байна. Үүнд: Өмнө нь ажиллаж байсан удирдлагатай холбоотой дутагдсан 6.0 сая төгрөгийн 3 ширхэг компьютерийг холбогдох эзнээр нь төлүүлж орлогодсон. “Оюу толгой” ХХК-иас авах ажлын хөлс 173.5 сая төгрөгийн он дамжсан авлагыг шүүхээр шийдвэрлүүлэх нэхэмжлэлийг Захирлын 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 341 тоот албан тоотоор хүргүүлсэн, хүчингүй тамга тэмдэг, гарын үсгийн бүрдэлгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх талаар өгсөн 3 зөвлөмжийг биелүүлж ажилласан байна. Бараа материалыг шууд зардлаар бүртгэхгүй байх зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй байна.

1.13 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгов.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцож 2017 оны орлогын тайлангийн нийт орлого 598.8 сая төгрөгийн 1 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тус байгууллага нь өмнөх оны аудитын дүгнэлтээр “хязгаарлалттай” дүгнэлт авсан ба өгсөн зөвлөмжийн 75 хувийг биелүүлж ажилласан байдлыг үндэслэсэн болно.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.





МОНГОЛ УС ТӨУҮГ-Н 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Авлага, өглөгийн талаар.....	3
Асуудал 2	
Бараа материалын талаар.....	4

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1	
Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар.....	5
Асуудал 2	
Дотоод хяналтын талаар	6

2018 оны 3 дугаар сар



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Монгол Ус” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Монгол Ус” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**1.15 Асуудал 1: Авлага, өглөгийн
ТАЛААР**

1.16 ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

ҮАГ-ын ажиглалт

Харилцагч байгууллага, хувь хүмүүсээс авах 12.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Тайлангийн хугацаанд харилцагч байгууллагатай тооцоо нийлж өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвших.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлнэ.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга, иж бүрэн байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор баталгаажуулсан болно.



**1.17 Асуудал 2: БАРАА МАТЕРИАЛЫН
ТАЛААР**

1.18 ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант жилийн 1-5 сард бараа материалын тайлан гаргалт хангалтгүй, шатах, тослох материалын тайлан гаргаагүй, 4.8 сая төгрөгийн хангамжийн материал, 6.9 сая төгрөгийн шатах тослох материалыг шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалын байнгын системийн аргаар бүртгэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлнэ.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг, үнэн зөв байдал эдгээр батламж мэдэгдлүүдийг зөрчих эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор баталгаажуулсан болно.



**1.19 Асуудал 1: Үндсэн хөрөнгийн
элэгдлийн талаар**

1.20 Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо хүчингүй болсон Засгийн газрын 233 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан нь НББОУС-16-г мөрдөж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програмд өөрчлөлт оруулж НББОУС-16-г мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлнэ.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, оршин байх, хэмжилт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор баталгаажуулсан болно.



1.21 Асуудал 2: Дотоод хяналтын

ТАЛААР

1.22 ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

ҮАГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулаагүй нь “Нийтлэг журам батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын 2.2-т "Дотоод хяналт шалгалтын зорилго нь байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж байгаа ажил үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид холбогдох журмыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ҮАГ-т ирүүлнэ.

Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тодруулга ба толилуулга, оршин байх, хэмжилт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор баталгаажуулсан болно.

